

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН

ТУШААЛ

..... оны ..... сарын ..... өдөр

Дугаар ....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.1, 14.1, 15.1.4, 16.2, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 8 дугаар зүйлийн 8.1, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 3.7.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг зохион байгуулах, сургагч багшид эрх олгох журмыг нэгдүгээр, сургалтын үнэлгээний хуудсыг хоёрдугаар, сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг ханган шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (Ц.Ганчимэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т, арга зүйгээр ханган ажиллахыг Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир)-т тус тус үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

## **“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ БАЙДЛЫН ТУХАЙ СУРГАЛТ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАГЧ БАГШИД ЭРХ ОЛГОХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журам нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг түгээж, хандлагыг төлөвшүүлэх сургагч багш бэлтгэх, эрх олгох, сургагч багш нарыг давтан сургах, сургалт зохион байгуулахтай холбогдон гарах харилцааг зохицуулна.

1.2. Журам нь Монгол Улсын байгууллага, иргэн бүрт тэгш үйлчилнэ.

### **ХОЁР. СУРГАЛТЫН АГУУЛГА, ХЭЛБЭР**

2.1. “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт” /цаашид “сургалт” гэх/ гэдэг нь хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцоход тохиолдож байгаа саад, бэрхшээлийг арилгах үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор оролцоонд тулгуурлан багийн зохион байгуулалттайгаар хийгддэг сургалтыг хэлнэ.

2.2. Сургалтын агуулга нь хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар болон үйл ажиллагааны төлөвлөгөө гэсэн үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд сургалтын агуулгыг өөрчлөхийг хориглоно.

2.3. Сургалтыг захиалагч байгууллагын хүсэлтэд үндэслэн сургалтын хөтөлбөрт өөрийн болон бусад нэр бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьдралын тухай сайн жишээ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрхэн зөв зохистой үйлчилгээ үзүүлэх гэх мэт сэдвийг тусгаж болно.

2.4. Сургалт нь дараах хэлбэртэй байна:

2.4.1. Танилцуулах сургалт: 1 цаг 30 минутаас илүүгүй хугацаанд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаар тайлбарласан лекц хэлбэртэй байна.

2.4.2. Бүрэн хөтөлбөрт сургалт: Гурван цагаас багагүй хугацаагаар үргэлжлэх бөгөөд журмын 2.1-д заасан агуулгаар хэлэлцүүлэг өрнүүлж, оролцоог хангасан багаар ажиллах хэлбэрээр зохион байгуулна. Сургалтанд оролцогчдын тооноос хамаарч гурваас доошгүй сургагч багш хамтран зохион байгуулна.

2.4.3. Багц сургалт: 6 цагаас багагүй хугацаагаар үргэлжлэх бөгөөд журмын 2.3.2 дахь Бүрэн хөтөлбөрт сургалтаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх арга зүйг эзэмшүүлэхэд чиглэсэн онол, дадлагыг хослуулсан сургалт байна. Тус сургалтыг тухайн бэрхшээлийн хэлбэрээр дагнан үйл ажиллагаа явуулдаг, энэ чиглэлээр дагнан сургалт хийж байсан туршлагатай төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

## **ГУРАВ. СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ**

3.1 Сургагч багшийг зөвхөн багш бэлтгэх эрх бүхий Трэйнер багш бэлтгэнэ.

3.2. “Сургагч багш” гэдэг нь холбогдох сургалтад хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тус сургалтыг зохион байгуулах эрхтэйг нотолсон гэрчилгээтэй хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэнийг хэлнэ.

3.3. “Трэйнер багш” гэдэг нь Ахлах сургагч багшаар хоёроос доошгүй жил ажилласан, хориос доошгүй удаа үндсэн сургалт зохион байгуулсан туршлагатай, Трэйнер бэлтгэх хөтөлбөрт амжилттай хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон Сургагч багш бэлтгэх эрхтэйг нотолсон гэрчилгээтэй хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн;

3.4. Сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах бөгөөд сургалтын үргэлжлэх хугацаа нь 60 цагаас багагүй байна.

3.5. Сургалт зохион байгуулахаас хоёроос доошгүй сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлана.

3.6. Хамрагдах хүсэлтэй иргэд сургалт зохион байгуулагдахаас нэг сарын өмнө цахим хэлбэрээр дараахь материалыг сургагч багш сонгон шалгаруулах ажлын хэсэгт ирүүлнэ:

3.6.1. Өргөдөл;

3.6.2. Ажилладаг бол байгууллагын, суралцдаг бол сургуулийн тодорхойлолт;

3.6.3. Боловсрол эзэмшсэнийг гэрчлэх холбогдох бүх бичиг баримт.

3.7. Трэйнер багш, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулна. Тус ажлын хэсэг иргэдийн ирүүлсэн материалыг хянаж, ярилцлага хийн сургалт болохоос 14 хоногийн өмнө иргэнд хариуг мэдээллэнэ.

3.8. Сургагч багшийн сургалтад хамрагдах иргэн дараахь шаардлагыг хангасан байна:

- 3.8.1. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой;
  - 3.8.2. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон;
  - 3.8.3. Эрүүл мэндийн хувьд сургалтад бүрэн хамрагдах боломжтой;
  - 3.8.4. Сургалтын агуулгыг бусдад ойлгуулах, түүнийгээ тайлбарлах чадвартай;
  - 3.8.5. Багаар ажиллах, бусдыг манлайлах чадвартай;
  - 3.8.6. Компьютерийн хэрэглээний Word, PowerPoint, Excel програмыг ашиглан илтгэл тавих, тайлан бичих чадвартай;
  - 3.8.7. Сонсголын бэрхшээлтэй бол монгол дохионы хэлээрболон бичгийн хэлээр харилцах чадвартай;
  - 3.8.8. Сургалтын хугацаанд үндсэн ажил болон сургуулиас чөлөөлөгдөж сургалтад бүрэн хамрагдах боломжтой.
- 3.9. Сургагч багш бэлтгэх нэг удаагийн сургалтад хамрагдах хүний тооны дээд хязгаар 20 хүн байна.
  - 3.10. Шинээр эрх авсан сургагч багш дадлага сургалтыг эрх авснаас хойш нэг сарын дотор заавал зохион байгуулж, тайланг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.
  - 3.11. “Дадлага сургалт” гэдэг нь сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдан төгсөж, эрхийн гэрчилгээ авсан багш нарын зохион байгуулж байгаа эхний сургалтыг хэлнэ.
  - 3.12. Сургагч багшийн эрх авснаас хойш арваас доошгүй удаа сургалтын үндсэн багшаар ажилласан, сургалтын дараах үнэлгээгээр оролцогчдын 85-аас багагүй хувь нь сургагч багшийн үр чадвар, сургалтын үр дүнг хангалттай гэж үнэлсэн, давтан сургалтад тогтмол хамрагддаг сургагч багшийг ахлах сургагч багшийн мэргэшүүлэх сургалтад хамруулан ахлах сургагч багшийн эрх олгож болно.
  - 3.13. Трэйнер багш улирал бүр сургагч багш нарт зориулсан давтан сургалтыг зохион байгуулна.
  - 3.14. “Давтан сургалт” гэдэг нь Трэйнер багш сургагч болон ахлах сургагч багш нарын сургалтын үр дүнг сайжруулах зорилгоор сар, улирал тутам Трэйнер багшийн зохион байгуулж байгаа сургалтыг хэлнэ.
  - 3.15. Сургагч багш бэлтгэх болон давтан сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт тусгана.

3.16. Сургагч багшийг орон нутаг, байгууллагын захиалгаар бэлтгэсэн бол захиалагч байгууллага тухайнсуралцагчийн сургалтад хамрагдахтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

## **ДӨРӨВ. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛБӨР, ЖИШИГ ҮНЭ**

4.1. Сургалт нь төлбөртэй байх бөгөөд шаардлагатай тохиолдолд төлбөргүй зохион байгуулж болно. Дараахь тохиолдолд төлбөргүй зохион байгуулж болно.

4.1.1. Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад туслалцаа үзүүлэх зорилгоор;

4.1.2. Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор;

4.1.3. Улс оронд тохиолдсон онц байдлын үед шаардлага гарсан тохиолдолд;

4.1.4. Бэлтгэгдсэн сургагч багштай төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд;

4.1.5. Хамтран ажиллах санамж бичигтэй байгууллагын үйл ажиллагааг дэмжих хүрээнд.

4.2. Төлбөртэй сургалтыг Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал сургалтын чиглэлээр мэргэшсэн, эсхүл эрх бүхий сургагч багштай төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан зохион байгуулна.

4.3. Энэ журмын 4.2-т заасан байгууллагатай хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрээ байгуулна.

4.4. Гэрээ байгуулах байгууллагыг сонгоход дараахь үзүүлэлтийг харгалзана:

4.4.1. Журмын 3.10-т заасан сургалтад сургагч багш нар нь 90-ээс доошгүй хувийн ирцтэй оролцсон;

4.4.2. бүтэн хөтөлбөрт сургалтыг зохион байгуулах сургагч багш, туслах ажилтан зэрэг хүний нөөц хангалттай;

4.4.3. сургалтын тайланг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан байгууллагад гэрээний болон санхүүгийн хугацаандаа хүргүүлдэг.

4.5. Бүрэн хөтөлбөрт сургалтад оролцогчдын тооноос хамааран дараах төлбөртэй байна:

4.5.1. Сургалтад 11-20 хүртэлх хүн хамрагдах бол 200.000 төгрөг;

4.5.2. Сургалтад 21-30 хүртэлх хүн хамрагдах бол 300.000 төгрөг;

4.5.3. Сургалтад 30-аас дээш хүн хамрагдах бол нэмэгдсэн хүний тоогоор 10.000 төгрөг нэмэгдүүлж тооцно..

4.6. Танилцуулах сургалт нь оролцогчдын тооноос үл хамааран 200.000 төгрөг байна.

4.7. Багц сургалт нь 600.000 төгрөгийн төлбөртэй байна. Багц сургалтад хамрагдах хүмүүсийн тооны дээд хязгаар 30 хүн байна.

4.8. Тухайн сургалтад гүйцэтгэж байгаа үүрэг, оролцооноос хамааран Сургагч багшийн цагийн хөлс 30,000-100,000 төгрөг, туслах ажилтан 20,000-30,000 төгрөгний хөлстэй байна.

4.9. Сургалтын зохион байгуулалттай холбоотой бусад зардлын хэмжээг Засгийн газраас тогтоосон жишиг үнээр тогтооно.

4.10. “Туслах ажилтан” гэдэг нь сургагч багш нарын хийж чадахгүй үйлдэл, сургалтын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй хүнийг хэлнэ.

## **ТАВ. СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Сургалтын хэрэгцээг тодорхойлох, тухайн жилд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

5.1.2. Бусад байгууллага, орон нутгаас сургалтын талаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч холбогдох төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.3. Сургалтыг зохион байгуулахад шаардлагатай зардлын асуудлаар холбогдох байгууллагад чиглэл өгөх, шийдвэрлүүлэх;

5.1.4. Сургалт зохион байгуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төрийн бус байгууллагаас хүлээн авч үнэлэх, нэгтгэх;

5.1.5. Сургагч багш нарыг хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр зохион байгуулагдаж байгаа сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамруулж, чадавхжуулах

5.2. Төрийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн болон бусад үйлчилгээг хүргэх ажлыг гүйцэтгэх байгууллага, аж ахуйн нэгжийн холбогдох удирдлага, ажилтан хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт олгох сургалтад сургалтад заавал хамрагдсан байх үүрэгтэй бөгөөд сургалттай холбогдон гарах төлбөрийг тухайн байгууллага өөрөө хариуцна.

5.3. Төрийн бус байгууллагууд сургагч багш нараа чадавхижуулах, давтан сургалтад хамруулах, тайлангаа тогтсон хугацаанд холбогдох байгууллагад ирүүлж байх үүрэгтэй.

## **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

6.1. Сургалтын материал болон хөтөлбөр зохиогчийн эрхээр хамгаалагдсан байна. Сургагч багш сургалтын материал /софт болон хард бүх төрлийн гарын авлага/-ыг зохистой эзэмших болон зохиогчийн эрхийг хамгаалах үүрэгтэй.

6.2. Сургалтын материалыг бусдад дамжуулж, олон нийтэд тараах зэрэг зөрчил гаргасан сургагч багшийн сургалт зохион байгуулах эрхийг цуцалж, холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно

6.3. Сургалтыг сургагч багшийн эрхгүй хүнээр зохион байгуулсан тохиолдолд тухайн байгууллагын сургалт зохион байгуулах гэрээг цуцална.

----oo0oo----

ТӨСӨЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
..... оны ..... дугаар сарын .... –ны өдрийн .....  
тушаалын Хоёрдугаар хавсралт

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ БАЙДАЛ СУРГАЛТЫН ДАРААХ ҮНЭЛГЭЭ

1. Оролцогчийн нэр----- Хүйс----- Ажилладаг байгууллага -----

2. Сургалтын агуулгаар авсан таны үнэлгээ (харгалзах нүдэнд тэмдэглэнэ үү)

	Дасгал ажил	Үнэлгээ		
		Хангалт-тай	Дунд зэрэг	Хангалт-гүй
1.	Дасгал ажил: Хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлоо хуваалцах дасгал			
2.	Дасгал ажил: Дэлгүүрт худалдан авалт хийх үеийн харилцааны тухай эргэцүүлэх дасгал			
3.	Багийн ажил: Хөгжлийн бэрхшээл хаана байгаа тухай ярилцах дасгал			
4.	Хэлэлцүүлэг: Видео үзэж анализ хийх			
5.	Дасгал ажил: Асуудал шийдвэрлэх арга замын талаар /од, хайрцаг/			
6.	Дасгал ажил: Асуудал шийдвэрлэх арга замын талаар /спортын ордон/			
7.	Үзүүлэн: Бүх хүн амьдрах таатай орчин, нөхцөл бүрдүүлэх сайн жишээний тухай			
8.	Багийн ажил: Өөрийн байгууллагыг хүртээмжтэй болгох тухай			

3. Сургагч багш нарын ур чадварт өгөх таны үнэлгээ (харгалзах нүдэнд тэмдэглэнэ үү)

Сургалтын агуулгаар	Үнэлгээ			
	Маш сайн	Сайн	Дунд	Муу
Үндсэн багш				
Үндсэн багш				
Чиглүүлэгч багш /зөвхөн тухайн оролцогчтой хамтран ажилласан багшийг үнэлнэ/				



4. Сургалтын ерөнхий зохион байгуулалтад өгөх үнэлгээ(харгалзах нүдэнд тэмдэглэнэ үү)

	Сайн	Дунд	Муу
Сургалтын хөтөлбөрийн агуулга, ач холбогдол			
Сургалтын хөтөлбөрийн шинэлэг байдал			
Сургалтын байр			
Сургалтын гарын авлага, материал			
Завсарлагаа (цай, нарийн боов гэх мэт)			
Цаг ашиглалт			
Сургалтын үргэлжлэх хугацаа			

5.Сургалтын үеэр зохион байгуулсан хэлэлцүүлэг, ярилцлагад Та ямар дүгнэлт хийж байна вэ?

6. Энэ сургалтаас авсан ойлголт, мэдээллээ цаашид ажил үүргээ гүйцэтгэхэд хэрхэн ашиглах вэ?

7. Та цаашдаа ямар чиглэлээр давтан сургалтанд хамрагдахыг хүсч байна вэ?

8.Сургалтад хамрагдсанаар цаашид ямар байгууллагатай хамтран ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?

9. Сургалт зохион байгуулахдаа цаашид анхаарах асуудлууд

10. Нэмж хэлэх санал

Танд баярлалаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
 ..... оны ..... дугаар сарын .... –ны өдрийн .....  
 тушаалын Гуравдугаар хавсралт

Сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр

№	Модулийн нэр	Хугацаа /цаг/	Агуулга /товч тайлбар/
1	Нээлтийн үйл ажиллагаа	0.5	Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах трэйнэр багш, туслах үүрэгтэй оролцож байгаа ахлах сургагч багш нар болон сургалтын ерөнхий зохион байгуулалтыг хариуцан ажиллаж байгаа хүмүүстэй танилцах хэсэг.
2	Сургалтын танилцуулга	3.0	DET сургалт болон DET сургагч багш нарын талаар, энэ сургалтын үр дүнд олон улсад болон Монгол Улсад ямар өөрчлөлт гарсан зэрэг мэдээллийг өгөх хэсэг.
3	DET үзүүлэн сургалт	3.0	Бүрэн хөтөлбөрт сургалтыг оролцогчдод үзүүлэн байдлаар зохион байгуулж үзүүлэх хэсэг.
4	DET гэж юу вэ?	3.0	DET сургалтын онцлог, агуулга, бүтэц, арга, зарчмын тухай ойлголт өгнө. Хөгжлийн бэрхшээлийг биеэр мэдрэх /DAT/ сургалтаас ямар ялгаатайг ойлгуулах хэсэг.
5	Дадлага: Илтгэл	1.5	Илтгэл тавих чадвар сургагч багшид байх ёстой чадваруудын нэг гэдгийг ойлгуулж, илтгэл хэрхэн тавих, юунд анхаарах зэрэг ойлголтуудыг өгөх хэсэг.
6	Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар	7.5	Сургагч багш хүний нийгмийн загварын тухай зайлшгүй мэдсэн байх түвшин буюу 4,7,9 дүгээр түвшинг үзнэ. Энэ үед оролцогчид хувь хүний загвар нийгмийн загвар хоёрыг ялгаж чаддаг болсон байх, хөгжлийн бэрхшээл, бие эрхтний бэрхшээлийг ялгаж чаддаг болсон байх, тусгаарлах гэдэг үгийг ойлголт өгөх хэсэг.
7	Дадлага: Чиглүүлэх ур чадвар	7.5	Бүрэн хөтөлбөрт сургалтын үеийн дасгал ажлуудыг хэрхэн чиглүүлэх тухай лекц, үзүүлэн хосолсон хэсэг.
8	DET сургалтын материал (1: I am You)	1.5	Асуудал хөндсөн бичлэг үзүүлж, бие эрхтний бэрхшээл нь хөгжлийн

			бэрхшээлийг үүсгэдэггүй тухай ойлголтыг оролцогчдод өгч, өөрсдөөр нь анализ хийлгэх замаар асуудлыг олж харах чадвар суулгах хэсэг.
9	DET сургалтын материал (2: Talk)	1.5	Асуудал хөндсөн бичлэг үзүүлж, бие эрхтний бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэггүй тухай ойлголтыг оролцогчдод өгч, өөрсдөөр нь анализ хийлгэх замаар асуудлыг олж харах чадвар суулгах хэсэг.
10	DET агуулгыг тоймлон үзэх (эхний хэсэг)	1.5	DET сургалтын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт авах, нийгмийн загварыг таньж мэдэх эхний хэсгийг тоймлон орох хэсэг.
11	Бэлтгэл ажил	4.5	Сургагч багшаар бэлтгэгдэж байгаа хүмүүс сургалтын эхний хэсгийг бие биедээ үзүүлэн сургалт хийж шүзүүлэх дадлага ажилтай холбоотой зөвлөгөө өгөх хэсэг.
12	DET Дадлага ажил (1)	3.0	DET сургалтын эхний хэсгийн дадлага ажил. Оролцогчид 4 баг болон хуваагдаж, хоёр хоёроороо дадлага сургалт зохион байгуулах хэсэг.
13	Эхний хагасын дүгнэлт	1.5	Сургалтын эхний хагасын дасгал ажлуудын гол зорилго, анхаарах зүйл, дадлага ажлын үеэр нийтлэг гаргасан алдаа зэргийг тайлбарлаж, эргэн сануулах дүгнэлт хэсэг.
14	Үйл ажиллагаа	4.5	Сургалтын эцсийн зорилго нь нийгмийн загварын ойлголттой болох биш харин сургалтад оролцсон ямар ч хүн сургалтаас гарахдаа саадыг арилгах төлөвлөгөө буюу үйл ажиллагаатай гарах ёстой, тийм зүйл рүү чиглүүлэх ёстойг ойлгууж, DET сургалтаар ямар үйл ажиллагааг дэмждэг, ямар үйл ажиллагааг дэмждэггүйг ойлгуулах хэсэг
	DET агуулгыг тоймлон үзэх (сүүлийн хэсэг)	1.5	DET сургалтын үед үйл ажиллагааг хэрхэн чиглүүлэх, дасгал ажлуудыг хэрхэн ажиллуулах, чиглүүлэх асуултыг хэрхэн тавих зэрэг сүүлийн хэсгийн давтлага хэсэг.
	DET Дадлага ажил (2)	3.0	DET сургалтын сүүлийн хэсгийн дадлага ажил. Оролцогчид 4 баг болон

			хуваагдаж, хоёр хоёроороо дадлага сургалт зохион байгуулах хэсэг.
15	DET Сургагч багш бэлтгэх сургалтын дүгнэлт	1.5	Бүх дасгал ажлуудыг нэгтгэн анхаарах ёстой зүйлс, дасгал ажлуудын зорилго, хүрэх үр дүнгийн талаар, оролцолгчдоос ирдэг нийтлэг асуултад хариулах гэх зэргээр сургалтыг нийтэд нь дүгнэх хэсэг. Мөн оролцогч, зохион байгуулагч хүн бүрийн сэтгэгдлийг сонсох хэсэг.
16	НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	1.5	Сургагч багш болгон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн тухай мэдлэг, мэдээлэлтэй байх ёстой. Конвенци батлагдах болсон шалтгаан, нөхцөл байдал, конвенцийн агуулга, Монгол Улс дахь хэрэгжилтийн байдал зэрэг мэдээлэл өгөх хэсэг.
17	Дүгнэлт (өдөр бүр)	7.5	Трэйнэр болон ахлах сургагч багш нар өдөр бүр оролцогчидтой сургалтын дараахь дүгнэлт яриаг хийж, сайжруулах зүйлс болон сургалтаас олж авсан агуулгын талаар ярилцах хэсэг.
18	Хаалтын үйл ажиллагаа	1.0	Оролцогчдод сургагч багшийн эрхийн бичгийг гардуулах хэсэг.
	Нийт	60.0	